

# 'ХОГНООС АНГИЖИРЪЯ' ТУНХАГ

## ХОГ ХАЯГДЛЫН ХЯМРАЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

2023 ОНЫ 3 ДУГААР САР

Монгол улсад тулгарч буй хог хаягдлын хямралыг шийдвэрлэхэд баримтлах дараах зарчмуудыг үзэл санаа, үйл хэрэгтээ нэгдмэл байдлаар тусгаж ажиллахаа би/бид баталж байна:

1. **Тогтвортой** хэв маягаар амьдарч, эдийн засгаа эргүүлэн **тойрог** болгохыг зорино.
2. **Нийгмийн шударга ёс** бидний ёс суртахууны луужин байна.
3. Хог хаягдлын хямралыг шийдвэрлэхэд **эдийн засгийн шилжилт хэрэгтэй**.
4. Хаана ч **системтэйгээр** өргөжүүлэн **нэвтрүүлэх** боломжтой **шийдлүүдийг** эрэлхийлнэ.
5. **Орон нутгийн онцлогт тохирсон** шинэлэг, зоримог шийдлийг эрэлхийлнэ.
6. **Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагыг** хуулиар хүлээлгэх нь хог хаягдлын хямралыг шийдвэрлэх гол шийдэл мөн.
7. Хог хаягдал зохицуулах нь **олон нийтийн үйлчилгээ** байх ёстой.
8. **Хог хаягдлын гарцыг** анхнаас нь **бууруулах** нь бидний хамгийн гол зорилго.
9. **Дахин боловсруулалт** нь бүх асуудлыг шийдвэрлэдэг **шидэт шийдэл биш**.
10. **Дахин боловсруулалт** болон **зэрэг бууруулж боловсруулах** нь том **ялгаатай**.
11. Ямар ч тохиолдолд **хог шатаахыг эсэргүүцнэ**.
12. **Байгалийн** гаралтай **хаягдлыг хөрсөнд** шингээхийг эрмэлзэнэ.
13. Гэртээ **хогоо ангилах** нь чухал боловч **дангаараа хангалтгүй**.
14. **Нэг удаагийн** болон **эдэлгээ муутай бүтээгдэхүүнийг хориглохыг** бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдаас шаардана.
15. **Сав баглаа боодлыг стандартчилж, эргүүлэн татах** тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.
16. Хуванцрын бохирдлыг бууруулах **олон улсын албан ёсны гэрээнд** нэгдэхийг уриална.

Эдгээр зарчмуудыг дараагийн 3 хуудсанд нэг бүрчлэн дэлгэрэнгүй тайлбарлав

Байгууллага: .....

Нэр: .....

Албан тушаал: .....

Огноо: .....

Гарын үсэг:



# 'ХОГНООС АНГИЖИРЪЯ' ТУНХАГ

## ХОГ ХАЯГДЛЫН ХЯМРАЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

2023 ОНЫ 3 ДУГААР САР

Энэхүү Тунхагийн **16 заалт** нь Монгол улсад тулгарч буй хог хаягдлын хямралыг шийдвэрлэхийн тулд үзэл санаа, үйл хэрэгтээ баримтлах зарчмуудыг тодорхойлох зорилготой юм. Дэмжигч байгууллага, хувь хүмүүс бүхий л нөөц бололцоогоороо эдгээр зарчмуудыг таниулан сурталчилах үүрэг хүлээнэ.

1

### ТОГТВОРТОЙ ХЭВ МАЯГААР АМЬДАРЧ, ЭДИЙН ЗАСГАА ЭРГҮҮЛЭН ТОЙРОГ БОЛГОХЫГ ЗОРИНО

Хог хаягдлын хямралтай тэмцэх хичээл зүтгэл нь амьдралын хэв маягаа эргээд ёс зүйтэй, тогтвортой байлгах томоохон тэмцлийн нэгэн хэсэг билээ. Зогсолтгүй өсөн тэлж буй үйлдвэрлэл, хэрэглээнд суурилсан капиталист эдийн засгаа эргэн харахгүйгээр бид хог хаягдлын асуудалд шийдэл олох боломжгүй юм. Урт хугацааны шийдлүүд нь эдийн засгийг тойрогт оруулж, экосистем болон байгалийн нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаж байвал жинхэнэ шийдэл мөн. Нэг талд асуудал шийдэж байгаа мэт боловч нөгөө талд бүр ч том асуудал үүсгэдэг шийдлүүд нь хуурмаг шийдэл юм.

2

### НИЙГМИЙН ШУДАРГА ЁС БИДНИЙ ЁС СУРТАХУУНЫ ЛУУЖИН БАЙНА

Хог хаягдлын хямралыг шийдвэрлэх шийдлүүд нь зөвхөн байгаль орчинд эерэгээр нөлөөлөөд зогсохгүй нийгмийн шударга ёсыг бэхжүүлж, орон нутгийн иргэдийг чадавхжуулан иргэдэд ч үр шимээ өгөх ёстой. Бидний хэрэгжүүлж буй ажлууд иргэдэд, тэр дундаа эрсдэлт бүлгийн иргэдэд дарамт үзүүлж хэрхэвч болохгүй. Харин ч эсрэгээрээ, хог хаягдлын асуудлаас хамаарч эрх ашиг нь хамгийн ихээр зөрчигдсэн, хохирсон иргэд рүү бидний ажил чиглэж тогтвортой, хүсэмжит ажлын байрууд бий болгохын төлөө зорих учиртай.

3

### ХОГ ХАЯГДЛЫН ХЯМРАЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ЭДИЙН ЗАСГИЙН ШИЛЖИЛТ ХЭРЭГТЭЙ.

Өнгөрсөн хэдэн арван жилд тив дамжсан олон улсын худалдаа нэмэгдэж, үйлдвэрлэл - хэрэглээ хоорондын зай улам холдож, бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа уртсахын хэрээр баглаа, боодол асар ихээр ашиглагдаж байна. Хог хаягдлын гарцыг бууруулахын тулд орон нутгийн үйлдвэрлэгч, хэрэглэгчийг холбож дотоодын эдийн засгаа бэхжүүлэх нь хамгийн зөв шийдэл юм. Иймээс дотоодын ажлын байрыг хамгаалах, шинээр бий болгох нь ёс зүйн хувьд чухал төдийгүй хог хаягдлын хямралыг шийдвэрлэхэд ч зайлшгүй шаардлагатай.

4

### ХААНА Ч СИСТЕМТЭЙГЭЭР ӨРГӨЖҮҮЛЭН НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ШИЙДЛҮҮДИЙГ ЭРЭЛХИЙЛНЭ

Жинхэнэ шийдэл нь амьдарч буй газар, хөрөнгө, санхүүгийн чадамжаас үл хамаарч хүн бүрт хүртээмжтэй, эерэгээр нөлөөлөх ёстой. Хөрөнгөтэй хэсэг бүлэг хүмүүст л үр шимээ өгөх шинэ технологиуд нь хуурмаг шийдэл бөгөөд одоогийн эсвэл ирээдүйд үүсч болох ажлын байрыг ч үгүй хийх нь элбэг. Иймээс зөвхөн зарим газар хэрэгжих боломжтой эсвэл хэт өндөр өртөгтэй шийдлүүдийг жинхэнэ шийдэлд тооцохгүй.

5

### ОРОН НУТГИЙН ОНЦЛОГТ ТОХИРСОН ШИНЭЛЭГ, ЗОРИМОГ ШИЙДЛИЙГ ЭРЭЛХИЙЛНЭ

Хог хаягдлаа зохистой зохицуулдаг газар дэлхийд үгүй бөгөөд үсрэнгүй хөгжилтэй улсууд хог хаягдал зохицуулах зардал, ажиллах хүчийг ихэвчлэн гадагшлуулсан байдаг тул эдгээр улсуудын "сайн туршлага" гэгдэх өрөөсгөл шийдлүүдийг бид сохроор дагаж болохгүй. Боломжит хувилбар бүрийг бид өөрсдийн хараа, зарчимд нийцэх эсэхийг анхааралтай шалгаж зөвхөн орон нутгийн онцлогт нийцэх шийдлийг л хэрэгжүүлнэ. Хэрэв шаардлагатай бол шинэлэг, зоримог шийдэл нэвтрүүлэхээс бид няцахгүй.



6

## ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ӨРГӨТГӨСӨН ХАРИУЦЛАГЫГ ХУУЛИАР ХҮЛЭЭЛГЭХ НЬ ХОГ ХАЯГДЛЫН ХЯМРАЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ГОЛ ШИЙДЭЛ МӨН

Бидний хог хаягдлыг бүрдүүлдэг бараа бүтээгдэхүүн, сав баглаа боодлыг үйлдвэрлэж, борлуулдаг компаниуд нийгмийн хариуцлагаа хүлээж, хог хаягдал зохицуулахад бодитоор оролцох ёстой. Тухайлбал, компаниуд сайн дураараа нийгмийн хариуцлагаа бүрэн дүүрэн хүлээдэггүй тул бодлого боловсруулагчид үүнийг тодорхойлж үйлдвэрлэгчдэд албадан хариуцлага хүлээлгэх ёстой. Эдгээр томоохон компаниудын бүтээгдэхүүндээ хэрэглэж буй сав, баглаа боодлын амьдралын мөчлөгийг бүхэлд нь харгалзаж хариуцлага хүлээлгэх хатуу хууль дүрэм, журмаар зохицуулахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Үйлдвэрүүд хүн, байгальд ээлтэй, хорт бодисын агууламжгүй савлагаа, дизайн ашиглахын зэрэгцээ хог нэгэнт үүссэн бол түүнийг зохистой зохицуулах тогтолцоог газар сайгүй нэвтрүүлэхэд санхүү, логистикийн идэвхтэй, шууд оролцоотой байх шаардлагатай.

7

## ХОГ ХАЯГДАЛ ЗОХИЦУУЛАХ НЬ ОЛОН НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БАЙХ ЁСТОЙ

Аюулгүй, эрүүл орчинд амьдрах нь хүн бүрийн үндсэн эрх. Иймээс хог хаягдлын зохицуулалт нь эрүүл мэнд, боловсролын салбарын адил олон нийтэд хандсан үндсэн үйлчилгээ байх ёстой юм. Хэдийгээр хог хаягдал зохицуулалтын тодорхой сегментүүд, зарим нэр төрлийн хог хаягдал нь ашигтай бизнес байж болох ч хог хаягдал зохицуулахад орлогоос давсан зардалтай учир эдийн засгийн хувьд тогтвортой хог хаягдал зохицуулах цогц тогтолцоог бий болгоход бизнесийн байгууллага тохиромжгүй юм. Иймээс хувийн хэвшил хог хаягдал зохицуулах тогтолцооны зарим үйл ажиллагааг явуулах боломжтой ч төрийн бодлого, төрийн захиргаа нь олон нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж салбарын цөмийг хариуцах нь чухал.

8

## ХОГ ХАЯГДЛЫН ГАРЦЫГ АНХНААС НЬ БУУРУУЛАХ НЬ БИДНИЙ ХАМГИЙН ГОЛ ЗОРИЛГО

Бид бүхий л үйл ажиллагаагаа 3R зарчмын дагуу хог хаягдлын гарцыг эхнээс нь бууруулахад чиглүүлнэ. Үйлдэл бүрээ хог хаягдлын гарцыг бууруулахад хэрхэн нөлөөлж буй, цаашлаад хог хаягдал үүсэхээс сэргийлэхэд садаа болж, сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай эсэхийг тогтмол хянаж, тооцох нь чухал. Өөрөөр хэлбэл, бид анхнаасаа байх ёсгүй байсан хогийг үүссэн хойно нь дахин ашиглах, дахин боловсруулах шийдэл хайж явах учиргүй бөгөөд шаардлагагүй хог хаягдлыг үүсэхээс нь өмнө хориглох нь хамгийн зөв шийдэл юм.

9

## ДАХИН БОЛОВСРУУЛАЛТ НЬ БҮХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭДЭГ ШИДЭТ ШИЙДЭЛ БИШ

Хог хаягдлын хямралыг шийдвэрлэхэд дахин боловсруулалт тодорхой үүрэгтэй ч өөрөө олон асуудал, бэрхшээл дагуулдаг учир заримдаа огт шаардлагагүй, ашиглах ч боломжгүй байдгийг үргэлж санах хэрэгтэй. Дахин боловсруулах салбар дэлхий дахинд уналтанд орж байгаа хэдий ч нийгмийн тэгш бус байдалд дөрөөлж, эрсдэлт бүлгийн иргэдийн хөдөлмөрийг мөлжиж, эрүүл мэндийг сүйтгэн оршсоор байна. Эцэс төгсгөлгүй 100% дахин боловсруулна гэдэг нь хий хоосон мөрөөдөл бөгөөд дахин боловсруулалт бол бодит шийдлийн өчүүхэн хэсэг юм: олон сөрөг үр дагаварыг нь мэдэхгүйгээр дахин боловсруулалтад хэт анхаарч, хичээл зүтгэлээ зарцуулах нь алдаа болдог. Дахин боловсруулах үйлдвэрүүд хог хаягдлын хямралын асуудлыг дангаараа шийддэг шидтэн биш бөгөөд үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад нь хог хаягдал зохицуулах зохистой тогтолцоо тэдэнд зайлшгүй шаардлагатай юм.

10

## ДАХИН БОЛОВСРУУЛАЛТ БОЛОН ЗЭРЭГ БУУРУУЛЖ БОЛОВСРУУЛАХ НЬ ТОМ ЯЛГААТАЙ

Жинхэнэ дахин боловсруулалт болон зэрэг бууруулсан боловсруулалтын тухай албан ёсны тодорхойлолт байхгүй ч үр дүнтэй дахин боловсруулна гэдэг нь боловсруулах явцдаа маш бага хаягдал үүсгэдэг эсвэл бүр огт хаягдал үүсгэдэггүй, анхны бүтээгдэхүүнтэй нь ижил зэргийн бүтээгдэхүүн болгон хувиргахыг хэлнэ. Жишээ нь: хагархай шилийг дахин боловсруулж шинэ шил хийх. Харин үүний эсрэгээр зэрэг бууруулж боловсруулах гэдэг нь боловсруулах явцдаа их хэмжээний хаягдал үүсгэдэг, анхныхаас нь өөр бүтээгдэхүүн болгож хувиргахыг хэлнэ. Жишээ нь PET савыг зэрэг бууруулж хувцас, хивс гэх мэт бүтээгдэхүүн болгох ба эдгээр нь удалгүй хогийн цэгт эсвэл шатаах зууханд хаягддаг. Дахин боловсруулалт тойрог эдийн засгийг дэмждэг бол зэрэг бууруулж боловсруулах нь түүний эсрэг. Бид шийдлээ сонгохдоо энэ чухал ялгааг анхаарч “дахин боловсруулалт” гэдэг нэр томъёог буруугаар ашиглахтай тэмцэх ёстой. Дахин боловсруулах үйлдвэрүүдэд зэрэг бууруулж бус жинхэнэ дахин боловсруулалт хийхэд нь бид дэмжлэг болох учиртай.



11

## ЯМАР Ч ТОХИОЛДОЛД ХОГ ШАТААХЫГ ЭСЭРГҮҮЦНЭ

Хог шатаах мөн “хогноос эрчим хүч гаргаж авах” технологи нь шийдлээсээ илүү асуудал үүсгэдэг болох нь шинжлэх ухааны үндэслэлтэй батлагдсаар байна. Хог шатаахад хүн, амьтны эрүүл мэндэд маш хортой бодисууд ялгарахаас гадна байгаль орчин болон цаг уурын өөрчлөлтөд их хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг. Шатаах үйлдвэрүүд ашигтай ажиллахын тулд их хэмжээний хог шатаах шаардлагатай тул хог хаягдлын хэмжээг бууруулахад саад болоод зогсохгүй сайн шатдаг хуванцар ихтэй хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдтэй өрсөлдөж ангилалт, дахин боловсруулалтад чөдөр тушаа болдог. Хогноос эрчим хүч гаргаж авах үйлдвэрүүд анхны хөрөнгө оруулахаас эхлээд үйл ажиллагаа нь асар өндөр зардалтай бөгөөд эрчим хүч үйлдвэрлэх хамгийн өндөр өртөгтэй хэрнээ хамгийн үр ашиггүй аргуудын нэг юм. Монгол улсад тулгарч буй хог хаягдлын хямралыг шийдвэрлэхэд хог шатаах өнөөгийн технологиудаас нэвтрүүлэх үндэслэл огт байхгүй гэж бид үзэж байна.

12

## БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ ХАЯГДЛЫГ ХӨРСӨНД ШИНГЭЭХИЙГ ЭРМЭЛЗЭНЭ

Органик буюу байгалийн гаралтай ‘хаягдал’ нь хогийн цэгт хаягдах бус эргээд хөрсөнд шим тэжээл болж шингэх учиртай. Бидний өдөр тутмын амьдралд ногоо, амьтны гаралтай хаягдал ихээр үүсдэг тул бордоожуулах, органик хаягдал боловсруулах бусад арга замыг дэмжиж, нэвтрүүлэх нь нэн чухал. Цаашлаад нүхэн жорлонгийн эрүүл ахуй, байгаль орчны асуудлаас зайлсхийхэд хуурай жорлонгийн үндсэн зарчим болох бордоожуулалт нь шилдэг шийдэл болоод байна.

13

## ГЭРТЭЭ ХОГОО АНГИЛАХ НЬ ЧУХАЛ БОЛОВЧ ДАНГААРАА ХАНГАЛТГҮЙ

Нийт хог хаягдлын багахан хувийг л айл өрхийн хог хаягдал эзэлдэг. Иймээс иргэн бүр гэртээ хогоо ангилах нь чухал, үүнийг дэмжих хэрэгтэй ч үндсэн асуудал эх үүсвэр дээр нь буюу үйлдвэрлэлийн түвшинд үүсдэгийг үргэлж санах хэрэгтэй. Дунджаар бидний гэрээс гардаг 1 сав хаягдал тутамд хэрэглээний бүтээгдэхүүнүүд бидний гар дээр ирэхээс ч өмнө буюу үйлдвэрлэх явцдаа 70 сав хаягдал үүсдэг.

14

## НЭГ УДААГИЙН БОЛОН ЭДЭЛГЭЭ МУУТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХОРИГЛОХЫГ БОДЛОГО БОЛОВСРУУЛАГЧ, ШИЙДВЭР ГАРГАГЧДААС ШААРДАНА

Хог хаягдлын гарцыг бууруулах, цаашлаад нөөц баялгаа хамгаалахын тулд баглаа боодол гэх мэт нэг удаагийн бүтээгдэхүүн болон хувцас, тавилга гэх мэт бусад чанар муутай, насжилт богинотой элдэв эд зүйлс, бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг хориглох нь юу юунаас чухал. Иргэд худалдан авалтын сонголтоороо эдийн засгийн оролцогч талуудад нөлөөлөх боломжтой ч дангаараа хангалтгүй. Улс төрийн шийдвэр гаргагчид байр сууриа тодорхойлж, богино хугацаанд хог болдог бүтээгдэхүүнүүдийг хориглох зоримог хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

15

## САВ БАГЛАА БООДЛЫГ СТАНДАРТЧИЛЖ, ЭРГҮҮЛЭН ТАТАХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ

Дахин ашиглагдах ч бай, дахин боловсруулагдах ч бай бүх төрлийн савлагааг аль болох нэгдсэн стандарттай болгож хог хаягдал зохицуулах явцыг хөнгөвчлөх, дахин ашиглалт, дахин боловсруулалтын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах шаардлагатай. Ямартаа ч үйлдвэрлэгчид дахин ашиглагдах савлагаа ашиглах үүрэг хүлээж бусад талуудын зөв үйлдэлд найдахын оронд бүх төрлийн сав, баглаа боодлын хаягдлаа (худалдан авах шаардлага хангахгүй байсан ч) эргүүлэн татах тогтолцоог системтэй нэвтрүүлэх шаардлагатай юм.

16

## ХУВАНЦРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ОЛОН УЛСЫН АЛБАН ЁСНЫ ГЭРЭЭНД НЭГДЭХИЙГ УРИАЛАХ

2022 оны 3 дугаар сард болсон НҮБ-ын Байгаль орчны чуулга уулзалтын үеэр хуванцар үүсэхээс хог хаягдал болж бохирдуулах хүртэлх бүхий л үе шатыг хамаарах олон улсын албан ёсны гэрээг хэлэлцэх түүхэн шийдвэр гарсан. Бид Монгол Улсын Засгийн Газрыг энэхүү Тунхагийн зарчмуудыг нэг бүрчлэн авч үзээд, бохирдуулагчид хамгийн ихээр сурталчилдаг хуурмаг шийдлүүд бус бодит шилдэг шийдлийг хамгаалж энэхүү хэлэлцээрт идэвхтэй оролцохыг уриалж байна. Хэрэв улс орон бүр энэхүү хамтын гэрээнд нэгдэж чадвал хог хаягдлын хямралыг шийдвэрлэхэд томоохон алхам болох юм.





ЭКОСУМ ТББ, РД:8291276,  
Хаяг: 2А-3-01 5 дугаар баг,  
Хишиг-Өндөр сум, Булган аймаг  
Утас: 80142043  
Цахим хаяг: [contact@ecosoum.org](mailto:contact@ecosoum.org)  
Цахим хуудас: [www.ecosoum.org](http://www.ecosoum.org)

2023/03/16

## **“Хогноос ангижиръя” – Монгол улс дахь хог хаягдлын хямралыг шийдвэрлэхэд баримтлах зарчмуудын Тунхагт нэгдэхийг уриалах нь:**

Хог хаягдлын асуудалтай ямар нэг байдлаар тэмцэж буй эрхэм танаа,

2022 оны 3 дугаар сард болсон НҮБ-ын Байгаль орчны чуулга уулзалтын үеэр хуванцрын олборлолтоос авхуулаад хог хаягдал болж бохирдуулах хүртэлх бүхий л үе шатыг хамаарах [олон улсын албан ёсны гэрээг](#) хэлэлцэх түүхэн шийдвэр гарсан тухай та дуулсан болов уу. Засгийн газар хоорондын эхний шатны хэлэлцүүлэг 2022 оны 12 дугаар сард болж өнгөрсөн бөгөөд дараагийн түвшний яриа хэлцлүүд ирэх 2 жилд үргэлжилнэ.

Энэхүү олон улсын гэрээ нь хог хаягдлын чиглэлээр ажилладаг хэн бүхэнд хамаатай ба тухайн улс орондоо төдийгүй дэлхий нийтэд чухал томоохон өөрчлөлт авчрах ховорхон боломж юм. Дэлхий даяар мянга мянган байгууллага, эрдэмтэн судлаачид өөрсдийн засгийн газрыг энэхүү хэлэлцээрт ([www.plasticstreaty.org](http://www.plasticstreaty.org)) нэгдэхийг идэвхтэй уриалан ажиллаж эхлээд байна.

Цаг хугацаа урссаар, гэтэл энэ түүхэн мөч бидэнд ямар ховорхон боломжийг олгож байгааг Монгол улсад аль ч талдаа бүрэн ойлгож амжаагүй байгаа мэт санагдаж байна. Олон байгууллага хог хаягдлын эсрэг тэмцэн ажиллаж байгаа ч нэгдсэн тодорхой хүрээ, төлөвлөгөөгүйн улмаас бидний хичээл зүтгэл бодит үр дүнгүй тарамдаж байна.

Үүнийг өөрчлөхийн тулд Экосум ТББ-аас санаачлан Монгол улсад нүүрлэсэн хог хаягдлын хямралыг шийдвэрлэхэд баримтлах зарчмуудын Тунхагийг боловсруулсан (Хавсралтыг харна уу) бөгөөд энэ Тунхаг нь үйл ажиллагаагаа нэгдсэн зорилго, хүрээнд явуулахад чиг баримжаа болох зорилготой юм. ‘Хогноос ангижиръя’ Тунхагийн 16 заалт нь дэлхий дахинд энэ салбарт оройлон ажилладаг [Greenpeace](#), [GAIA](#), [Break Free From Plastic](#) зэрэг сүлжээ, хөдөлгөөнүүдийн баримтладаг үндсэн зарчмуудтай нийцэж байгааг онцлоё.

Тус Тунхаг нь ямар нэг тусгай шалгуургүйгээр хэн бүхэн өөрийн хүслээр нэгдэх боломжтой амлалт-андгайн хэлбэртэй юм. ‘Хогноос ангижиръя’ Тунхаг нь Монголын аль нэг холбоо, нийгэмлэг, сүлжээ байгууллагатай өрсөлдөх, шинээр албан ёсны бүлэг, холбоо байгуулах эсвэл хэн нэгний дуу хоолой болох цаашлаад хэн нэгэнд тушаал заавар өгөх зорилгогүй болно. Мөн ямар нэгэн удирдах дээд байгууллага, хяналтын хороо *байхгүй* бөгөөд уриалгад нэгдэх байгууллагууд Тунхагийн заалтуудаас үлбаатай ямар нэг эрсдэл хүлээхгүйгээр үйл ажиллагаагаа өөр өөрсдийн арга барилаар үргэлжлүүлэн явуулах бүрэн эрхтэй. ‘Хогноос ангижиръя’ Тунхаг нь улсынхаа хог хаягдлын хямралыг шийдвэрлэхийг хүссэн хэн бүхнийг нэгэн зүгт нэгтгэх цор ганц зорилготой юм.

Тунхагаа бид Монгол орон даяар эерэг өөрчлөлт авчрахаас гадна, хог хаягдалтай ямар нэг байдлаар тулж ажилладаг төр захиргаа, төрийн бус ашгийн бус байгууллагуудаас аваад дундын зуучлагч, дахин боловсруулагчид, дахивар түүгчид гээд бүхий л оролцогч талуудад ашигтай байхаар боловсруулсан. Эдгээр зарчмууд улс эх оронд маань төдийгүй та бидэнд өгөөжөө хэрхэн өгөхийг талууд дор бүрнээ харж чадна гэдэгт итгэлтэй байна. Хэрэв эдгээр зарчмуудыг далайцтай түгээж, бүх оролцогч талууд баримталж чадвал Монгол улс маань богино хугацаанд “хоггүй” улс болох бүрэн боломжтой гэдэгт бид огт эргэлзэхгүй байна.

2023 оны 4 дүгээр сарын эхээр бид ‘Хогноос ангижиръя’ Тунхагийг олон нийтэд түгээхэд зориулсан Фэйсбүүк эсвэл вэб хуудас нээх ба энэ нь аль нэгэн байгууллагын үйл ажиллагаа, дуу хоолойг дэмжихэд зориулагдахгүй бөгөөд зөвхөн Тунхаг болон түүнийг дэмжигч байгууллага, хувь хүмүүсийг олон нийтэд ил тод танилцуулна. Үүний тулд тус хуудаст Тунхагийг Монгол, Англи хэл дээр татаж болохуйцаар байрлуулах бөгөөд мөн Тунхагт нэгдсэнээ олон нийтэд таниулахыг зөвшөөрсөн дэмжигч байгууллагуудын нэрсийн жагсаалтыг шинэчлэн оруулж байна.

Тунхагт нэгдсэн байгууллагуудын гарын үсгээр баталгаажсан ‘Хогноос ангижиръя’ Тунхагийн хуулбар эсвэл байгууллагын төлөөлөл нь Тунхагийг барьсан зурагтайгаар дэмжигчдийн мэдээллийг хуудсаар дамжуулан түгээх бөгөөд хувь хүмүүс ч ялгаагүй Тунхагийг дэмжиж буйгаа илэрхийлж цахим хуудсанд мэдээллээ байрлуулж болно.

Тунхаг болон түүний зарчмуудыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор эхний ээлжинд бидэнтэй нэгдсэн байгууллагуудыг оролцуулсан бичлэг хийж ойрын хугацаанд хуудсаараа дамжуулж түгээхээр бид төлөвлөөд байна. Видео хийх болон бусад холбогдох зардлыг Экосум ТББ хариуцах бөгөөд та бүхэн тус видеонд оролцохыг хүсвэл нэн даруй бидэнд мэдэгдэж, Тунхагт нэгдэхийг уриалж байна.

Бид энэхүү албан захиа болон ‘Хогноос ангижиръя’ Тунхагийг хог хаягдлын салбарт идэвх санаачлагатай ажилладаг, мөн энэ тухайд сэтгэлээ чилээж явдаг өөрсдийн мэдэх хэн бүхэнд илгээж байгаа бөгөөд хэрэв аль нэг байгууллагыг орхигдуулсан бол хүлцэл өчье. Тунхаг нь нэгдэхийг хүссэн хэн бүхэнд нээлттэй учир бидэнтэй өөрсдийн санаачлагаар шууд холбогдох бүрэн боломжтой.

Бидний санаачилсан ‘Хогноос ангижиръя’ Тунхагийг та бүхэн нааштайгаар хүлээн авна гэдэгт бид итгэл дүүрэн байна.

Хүндэтгэсэн,

**ЭКОСУМ ТББ-ыг төлөөлж**

**ТЭРГҮҮН Г.НАРАНТУЯА**

